

Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:

Оллоо энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.

Доор дурдсан эрсдлийн хүчин зүйлүүдээс хамааран компани төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх магадлалтай. Эдгээрт:

- i. Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал
- ii. Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа компанийн бизнест нөлөөлөх
- iii. Хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд

Ирээдүйн орлогод нөлөөлөх эрсдлийг Оллоо ХХК өөрийн эрсдлийн бодлогыг хэрэгжүүлж түүнээс зайлсхийх эсвэл багасгаж чадах ч компанийн үйл ажиллагаанаас үл хамааран учрах эрсдлийн хүчин зүйлүүдээс 100 хувь зайлсхийж чадахгүй.

Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал:

Монгол улс 2006 онд ДНБ 8.3 хувь өссөн бөгөөд сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбар бүрт өсөлт ажиглагдаж байна. Эдийн засгийн өсөлтийн таамаглагдаагүй бууралт, улс төрийн тогтворгүй байдал нь хүн амын худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж ирээдүйн орлого таамаглаж байснаас бага болох магадлалтай байна. Эдийн засгийн уналттай холбоотой эрсдэлийг бууруулахын тулд компани тулгарч буй эрсдлийг тархаахын тулд шинэ зах зээл болон бүтээгдэхүүний салбарт нэвтрэн орсоор байх болно.

Компани үйл ажиллагаагаа хэвийн нь явуулж чадахгүй байх:

Компанийн хүний нөөцийн стратегийн төлөвлөгөө нь байгууллагыг чадвартай, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, ажлыг удирдан зохион байгуулах, ажилтнуудын хувийн чадварыг дээд зэргээр ашиглах, байгууллагын өөрчлөлт хөгжлийн бодлогод нийцүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, удирдах ба үйлдвэрийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа компанийн бизнест нөлөөлөх:

Өрсөлдөгч нартай өрсөлдөхүйц үнэ, чанараар өрсөлдөнө. Зах зээлд хэрэгцээт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, хүчин чадлаа нэмэгдүүлнэ.

Хууль эрх зүйн өөрчлөлтүүд:

Татварын хэмжээнд өөрчлөлт орох, гэх мэт эрх зүйн өөрчлөлтүүд компанийн үйл ажиллагаанд эсрэгээр нөлөөлж болно. Гэвч 2007 оноос аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, нэмүү өртгийн албан татварын хуульд өөрчлөлт орсон бөгөөд компани ойрын хугацаанд татвар өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

Интернетийн оролтын үнийн өсөлт:

Нийлүүлэгч нартайгаа урт удаан хугацааны нягт харилцааг тогтоож ажиллана. Жилийн гэрээг урьдчилан хийдэг нь үнийн өсөлтөөс сэргийлэх бодлогын нэг хэсэг билээ.